



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/453

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.г, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.1, 13.5.4, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргад хандаж гэр хүсч өргөдөл ирүүлсэн Есөнзүйл сумын 3 дугаар багийн иргэн Л.Батжаргалын гэр нь байгаль, цаг уурын аюулт үзэгдлийн улмаас амьдрах боломжгүй болсон, Арвайхээр сумын 7 дугаар багийн иргэн С.Дашдорж нь хүнд өвчтэй байнгын асаргаанд байдаг, тус багийн иргэн Т.Сугар нь хөгжлийн бэрхшээлтэй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, өөрийн гэсэн гэр оронгүй тул нэр бүхий 3 иргэнд гэртэй болоход нь зориулж 7,100,000 (долоон сая нэг зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх 7,100,000 (долоон сая нэг зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011101009